



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 3 сарын 19 өдөр

Дугаар С/11

Улаанбаатар хот


Үндэсний стандарт шинээр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3.1, 11.3.3, 11.3.4 дэх заалт болон Төмөр зам, далай ашиглалт, усан замын тээврийн стандартчиллын хороо (ТХ 33)-ны 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавсралтад дурдсан 3 нэрийн стандартыг улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар шинээр баталсугай.
2. Шинээр баталсан стандартуудыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Стандартыг сурталчилах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн яаманд зөвлөмжилсүгэй.


ДАРГА

Г. ГАНТӨМӨР



028012376

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2019 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн
С/11 дүгээр тушаалын хавсралт



Шинээр баталсан стандартын жагсаалт

№	Стандартын нэр	Стандартын дугаар
1	Төмөр замын тээврийн техникийн найдвартай байдлын үндсэн ойлголт. Нэр томъёо, тодорхойлолт	MNS 6387-5 : 2019
2	Төмөр замын ачааны вагоны барилга байгууламжийн зураг төслийн шаардлага	MNS TB 10031 : 2019
3	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний тоормосны нэр, томъёо тодорхойлолт	MNS EN 14478 : 2019